



БАЛИ АРЛЫН АДАЛ ЯВДАЛТ АЯЛАЛ

Урлагын арал, Хайрын арал, Бурхадын диваажин зэрэг олон нэршлийг өөртөө агуулж байдаг Индонезийн цор ганц Хинду шашинтай тус аралд ирсэнээр та ертөнцийн амар амгалан, ёр бусын тайвшралыг мэдрэх болно. Торго шиг зөөлөн элсэн дээр наранд биеэ шарж, далайн элдэв төрлийн амьтадтай хамт сэлж, далай доторх ертөнцөөр аялаж, зөвхөн Бали аралд л үзэх өвөрмөц урлагийн үзүүлбэрүүдийг сонирхон, байгалийн үзэсгэлэн бүрдсэн ширэнгэн ойд оюун бодлоо цэгцлэн иог хийх сайхан боломжийг бүү алдаарай. Бидний аяллаар рафтинг хийж, Батур уулаар аялан өглөөний мандах нарыг харж, будааны талбай, үзэсгэлэнт цэцэрлэгүүдээр хүрээлэгдсэн орчинд зочид буудалд амарч, Сулубан далайн эрэг дээр биеийн алжаал, стрессээ тайлж, Ванагири толгодоор аялан шувууны үүрэн хэлбэртэй савлуурт сууж эргэн тойрны байгалийг сайхныг ажиглах адал явдалт аяллуудыг хийх болно.

АЯЛЛЫН ДАВУУ ТАЛУУД

УБ-БАЛИ-УБ

Хонконг, Сөүл, Бээжин хотоор дамжин нисэх боломжтой

ГРУПП БҮРДЭЛТ ХҮЛЭЭХГҮЙ

ТОРГО ШИГ ЗӨӨЛӨН ЭЛСЭН ДЭЭР НАРАНД БИЕЭ ШАРАХ

РАФТИНГ ХИЙХ

УУЛАНД АЛХАЖ ӨГЛӨӨНИЙ
МАНДАХ НАРЫГ ХАРАХ

ЗӨВХӨН БАЛИД ҮЗЭХ
УРЛАГИЙН ӨВӨРМӨЦ ТОГЛОЛТ

EYELAND TRAVEL

80308585
80309393

Аяллын хөтөлбөр

Аяллын өдөр	Чиглэл	Үзвэр
1-р өдөр	<p align="center">УБ-Бали</p> <p>Хонконг, Сөүл, Бээжин, Шанхай хотуудаар дамжин нисэх боломжтой</p>	<ul style="list-style-type: none"> Улаанбаатар – Хонконг-Бали арлын чиглэлд ниснэ. /Нислэг 9 цаг үргэлжилнэ/ Нисэх онгоцны буудлаас орон нутгийн хөтөч тосч аван зочид буудалдаа очиж амарна.
2-р өдөр	<p align="center">Балигийн тойрон аялал</p> <p align="center">Сулубан далайн эрэг</p>	<p>Та өглөөний цайгаа уусны дараа өндөр давалгаа цавчлах далайн эргийн ойролцоо орших Танах Лот хийдээр зочлох болно. Дараа нь та бүхэн зориуд зоргож урласан гэлтэй цавчим хад асгатай Пандава далайн эргийг зорьж, үүний дараагаар сөрфгийн спортын төв цэг болсон Сулубан далайн эрэг дээр биеийн алжаал, стрессээ тайлаарай. Ийнхүү өдрийн турш адал явдлаар дүүрэн байсны эцэст та бүхэн дуу чимээтэй хотын төвөөс зайтай үзэсгэлэнт байгалийн дунд байрлах зочид буудалд байрлах болно.</p> <p align="right">/өглөөний цай, өдрийн хоол /</p>
3-р өдөр	<p align="center">Бали арал</p> <p align="center">Убуд-Мундук-Ванагири</p>	<p>Балигийн хойд хэсэгт байрлах уулархаг Мундук тосгон руу өглөө арай эрт хөдлөх бөгөөд тэнд та бүхэн хөтөчтэйгээ цуг Балигийн ширэнгэн ойн аяллаа эхлэх болно. Та бүхэн аяллынхаа үеэр кофе, какао гээд төрөл бүрийн ургамалтай таарахаас гадна хүрхрэнүүд таарах учир усны хувцсаа мартуузай. Мөн замдаа та Ванагири толгодоор дамжих бөгөөд тэнд шувууны үүрэн хэлбэртэй савлуурт сууж эргэн тойрны байгалийг ажиглан сууж, алжаалаа тайлах боломжтой. Ийнхүү гуравдах өдрийн аялал дуусч та бүхэн Убуд руу буцаж Ината Бисма зочид буудалдаа амраарай.</p> <p align="right">/өглөөний цай, өдрийн хоол/</p>
4-р өдөр	<p align="center">Бали арал</p> <p align="center">Үүрээр-Батур уул-Үдээс хойш рафтинг хийх</p>	<p>Энэ өдөр үүрээр Батур уулын нар мандахыг харах аялал хийнэ. Та бүхэн Батур уулан дээр гарч Бали арлын нар мандахыг хараарай. Үүний дараагаар уулын бэлд байх халуун рашаанд орж алжаалаа тайлах боломжтой. Халуун рашаанд орсны дараа таныг буудалд тань хүргэж өгөх бөгөөд та үд дунд хүртэл амарч байгаад рафтинг хийх аялалдаа гарах болно. Орой нь зочид буудалдаа амарна.</p> <p align="right">/өглөөний цай, өдрийн хоол /</p>
5-р өдөр	<p align="center">Бали арал</p> <p align="center">“Веноа” далайн эрэг- Чөлөөт цаг</p>	<p>Өглөөний цайгаа уусны дараагаар та бүхэн үзэсгэлэнт Веноа далайн эргийг зорих бөгөөд тэнд та бүхэн чөлөөт цагаа өөрийн тааваар өнгөрөөж усан спортын төрлүүдээр зугаацах боломжтой. Орой нь нисэх буудал явж бүртгэлээ хийлгэнэ.</p> <p align="right">/өглөөний цай/</p>

6-р өдөр	Бали-УБ	Шөнийн онгоцоор Улаанбаатар руу нисч аяллаа баяртайгаар өндөрлөнө.
----------	---------	--

Тайлбар

- 1) **Аяллын чиглэл:** Бали арлын аялал
- 2) **Аяллын хугацаа:** 5 шөнө, 6 өдөр
- 3) **Аяллын үнэ :**
 - Том хүн: 1.200.000₮ + тийзний үнэ
1.600.000₮+тийзний үнэ /зочид буудлын өрөөнд ганцаараа орох тохиолдолд/
 - Хүүхэд: 1.200.000₮+тийзний үнэ /зочид буудалд ортой явах тохиолдолд/
900.000₮+тийзний үнэ/ зочид буудалд оргүй явах тохиолдолд/
- 4) **Аяллын үнэд багтсан зүйлс:**
 - 3 одны зэрэглэлтэй зочид буудлын энгийн өрөөнд хоёулаа орох зардал
 - Хөтөлбөрт заагдсан үзвэр, үйлчилгээний зардал
 - Рафтинг хийх зардал
 - Хөтөлбөрт заагдсан хоолны зардал
 - Жуулчны тээврийн хэрэгслийн зардал
 - Аяллын хөтчийн үйлчилгээний зардал
 - Гадаад зорчигчийн иж бүрэн даатгалын хураамж
- 5) **Аяллын үнэд багтаагүй зүйлс:**
 - УБ-Бали-УБ чиглэлийн 2 талын нислэгийн тийзний үнэ
 - “Аяллын үнэд багтсан зүйлс”-ээс бусад зардал
 - Хувийн хэрэгцээний зардал
 - Нутгийн хөтчийн цайны мөнгө /10 ам.доллар/
- 6) Энэхүү хөтөлбөр нь аяллын жишиг хөтөлбөр бөгөөд аялал гарах үеийн нислэгийн хуваарийн өөрчлөлт, очих газар орны нөхцөл, валютын ханшны хэлбэлзэл зэргээс шалтгаалж хөтөлбөр болон аяллын үнэд өөрчлөлт гарч болно. Аялал гарах үед гэрээний хавсралтаар батлагдсан аяллын хөтөлбөр болон үнийг дагаж мөрдөнө.